

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

ДУГААР 13 | 2024.01 САР



ЭРДМИЙН БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2023-2024 оны хичээлийн жилийн өвлийн төгсөлтийн "Эрдмийн баяр"-ын үйл ажиллагаанд Мэргэжлийн боловсролын үнэмлэх, бүрэн дунд боловсролын гэрчилгээг 502 суралцагч, техникийн боловсролын дипломыг 9 суралцагч, нийт 17 мэргэжлээр 511 суралцагч төгсөж, Улс эх орныхоо хөгжлийг түүчээлэх шилдэг залуус тив дэлхийд өөрийн болон төрөлх сургуулийнхаа нэрээ цуурайтуулах ажил, амьдралын аянд нь арвин ерөөлөөр үдэн мордууллаа




Энэхүү хүндэтгэлийн арга хэмжээнд Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн захирал МУ-ийн зөвлөх багш Д.Буяндэлгэр, Сургалтын албаны менежер Б.Мядагдадам, ажил олгогч байгууллагыг төлөөлөн Сувдан тамир elektrik ХХК, Добу технологи ХХК, SS салон, Аряана Beauty салон, Туушин зочид буудал, Улаанбаатаор принт ХХК, Хилийн цэргийн 0288-р анги, Бөртэ ТӨҮҮГ зэрэг 30 гаруй ажил олгогчдын төлөөллүүд хүрэлцэн ирж, төгсөгчдөд ажлын байрны урилга гардуулж, төгсөгчдийн 70 хувь ажлын байраар хангагдлаа



БӨРТЭ” ТӨААТҮГ-ТАЙ 6 ДАХЬ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Бөртэ” ТӨААТҮГ-тай 6 дахь жилдээ амжилттай хамтран ажиллаж байна

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын эрх зүйн орчин сайжруулах, сургалтын стандарт, сургалтын орчин материаллаг баазыг хөгжүүлэх, суралцагчдыг үйлдвэр аж ахуйн нэгж дээр дадлагажуулж ажлын байран дахь ур чадварыг сайжруулах, мэргэжлийн багш нарын ур чадварыг дээшлүүлэхэд ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэх, харилцан туршлага судлах ажиллагааны хүрээнд “Бөртэ” ТӨААТҮГ-тай 6 дахь жилдээ амжилттай хамтран ажиллаж байгаа билээ. ҮҮПК захирал Д.Буяндэлгэр, “Бөртэ” ТӨААТҮГ-ын захирал дэд хурандаа Б.Ганжигүүр нар хамтран ажиллах гэрээг шинэчлэн дахин гэрээ байгууллаа.



Сургалт зохион байгуулагдлаа

Цахим хөгжлийн яамтай хамтран Засгийн газар хэрэгжүүлэгч агентлагаас төрийн өмчит үйлдвэрлэл үйлчилгээний бүхий л байгууллагуудад Монгол улсын Алсын хараа- 2050 бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа Цахим орчинд хэрхэн ажиллаж амьдрах нөхцөл боломж, эрх зүй", Цахим орчинд хэрхэн ажиллаж амьдрах нөхцөл боломж, эрх зүйн орчинд аюулгүй эрсдэлгүй байх ", "Тоон гарын үсгийн хэрэглээ" сэдвүүдээр 2 өдрийн сургалт явагдлаа.



Волейболын тэмцээнд ТЭРГҮҮН байранд шалгарлаа

Улаанбаатарын бүсийн “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш ажилтны дунд уламжлал болгон зохион байгуулагддаг Волейболын тэмцээнд манай баг тамирчид ТЭРГҮҮН байранд шалгарч шилдэг тоглогчоор Ч.Ариунтуяа шалгарлаа.



“Addie” загвар ашиглан цахим хичээл бэлтгэх сургалт зохион байгууллаа

Багш нарын цахим хичээл бэлтгэх арга зүйг дээшлүүлэх зорилгоор чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан ахлах ажилтан Лувсанвандан боловсролын парадигмийн шилжилт, суралцахуйн дизайн, суралцахуйн шатлал, цахим хичээлд “Addie” загвар ашиглах, цахим хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага зэрэг агуулгаар сургалт зохион байгууллаа.



Мэдээллийн технологийн багш нар "Ispring ашиглан цахим хичээл бэлтгэх нь" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



"PEARSON BTEC" ОЛОН УЛСЫН ИТ ХӨТӨЛБӨРИЙГ ТУРШИН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ 6 ПОЛИТЕХНИКИЙН АРГА ЗҮЙЧ, БАГШ НАР МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БАГШ НАР СУРГАЛТАНД ХАМРАГДЛАА

Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа - 2050”, Засгийн газрын 2020 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн төдийгүй мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэгээр нэрлэсэн. Энэ хүрээнд ирээдүйд шаардагдах мэдээллийн технологийн салбарын эрэлтийг хангах, боловсон хүчнийг бэлдэхийн тул олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Pearson BTEC international IT level 3 хөтөлбөрийг төрийн өмчийн 5 политехник коллеж, хувийн хэвшлийн 1 политехник коллежид энэ хичээлийн жилд туршин хэрэгжүүлж байгаа билээ.

Энэ хүрээнд политехник коллежийн мэдээллийн технологийн 20 гаруй арга зүйч, багш нар Улаанбаатар хотноо мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад хамрагдаж байна.

Сургалтаар Pearson BTEC хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний үйл явцыг зураглан тодорхойлох, 4 модулыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загварт оруулан боловсруулах, үнэлгээний аргачлал, төлөвлөгөө, даалгавар боловсруулах зэрэг дасгал, даалгаврыг багаар гүйцэтгэх бөгөөд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, дэмжлэг үзүүлэх, сайн туршлага, арга зүйг хуваалцах юм.

Pearson BTEC international IT Level 3 хөтөлбөр нь 71 улсын Засгийн газар, мэргэжлийн холбоод, ажил олгогч болон 300 гаруй их дээд сургуулиудаар хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд суралцагч дээрх орнуудын их дээд сургуулиудад дэвшин суралцах, мэргэжлээрээ ажил хөдөлмөр эрхлэх бүрэн боломжтой болох юм.

Монгол Улсад Ражив Гандийн Нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж, Техник Технологийн Политехник Коллеж, Өмнөговь Политехник Коллеж Дорнод Политехник коллеж Хөвсгөл аймаг дахь Политехник коллеж Ховд аймаг дахь Хөгжил Политехник коллеж Pearson BTEC international IT Level 3 хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан ёсны төвөөр тодорсон билээ.

Өнөөдрийн байдлаар дэлхийн даяар Pearson BTEC хөтөлбөрийн 800 гаруй албан ёсны төв үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд мэргэжлийн боловсролын 15 салбарт 2000 гаруй мэргэжлээр 1 сая суралцагч төгсөж байна.



ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОВ


Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Байгалийн ухаан болон Техник технологийн тэнхимийн багш нар Дархан-Уул аймаг дахь Политехник Коллеж - ДПК болон Сэлэнгэ аймаг дахь Политехник Коллежийн сургалтын үйл ажиллагаа болон орчинтой танилцаж сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, багш суралцагчдыг хөгжүүлэх олон тал үйл ажиллагааны талаар харилцан туршлага солилцож цаашид хамтран ажиллахаар боллоо



ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОВ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн багш нар Техник Технологийн Политехник Коллежоор зочилж сургалтын орчинтой танилцан, мэргэжил нэгт багш нартай уулзаж сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулалтын талаар харилцан туршлага солилцож цаашид хамтран ажиллах талаар санал солилцсон үр дүнтэй уулзалт боллоо

Биднийг хүндэтгэн хүлээн авсан Сургалт, оюутны албаны дарга Б. Мягмардорж, Сургалтын технологи хариуцсан ахлах мэргэжилтэн Ж. Хүрэлбаатар, ЕСУТ-ийн эрхлэгч Э. Энхтөр Хэлний сургалтын төвийн эрхлэгч Б. Ундрах болон бусад багш нар та бүхэндээ чин сэтгэлийн талархлаа илэрхийлье



УРЛАЛ ДИЗАЙНЫ ТЭНХИМИЙН БАГШ НАР МОНГОЛЫН УРЧУУДЫН ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ 11 ЗУРААЧ, УРАН БҮТЭЭЛЧДИЙН УРЛАНГААР ОРЖ ТУРШЛАГА СУДАЛЖ, ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО.

УРЛАЛ ДИЗАЙНЫ ТЭНХИМИЙН БАГШ НАР ТУРШЛАГА СУДАЛЛАА

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Урлал дизайны тэнхимийн багш нар Монголын Урчуудын эвлэлийн хорооны 11 зураач, уран бүтээлчдийн урлангаар орж туршлага судалж, хамтран ажиллахаар боллоо.



ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОВ

ХУТ-ийн гадаад хэлний хөтөлбөрийн багийн солонгос, англи хэлний багш нар 2 дугаар сарын 1-ний өдөр Олон улсын Улаанбаатар их сургуулийн гадаад харилцаа хариуцсан менежер С.Байгальмаа болон Солонгос хэлний боловсролын тэнхимийн багш, доктор Б.Ариунбаатар нартай уулзаж туршлага солилцон солонгос хэлний багш нарын заах аргазүй ба топикийн шалгалтад бэлдэх арга, гадаад хэл судлах аргазүйн талаар чөлөөт ярилцлага өрнүүлээ.

Мөн тус сургуулийн солонгос судлалын төв, солонгос судлалын хүрээлэнгийн харьяа номын сангийн үйл ажиллагаатай танилцан хамтран ажиллах боломжуудын талаар ярилцсан үр дүнтэй уулзалт болж доктор Б.Ариунбаатар өөрийн зохион гаргасан “Солонгос хэлний анхан шатны 400 үг тогтоох, хэрэглэх арга” номоо бэлэглэлээ.

ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОВ

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн мэдээллийн технологийн тэнхимийн багш нар Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн Мэдээлэл холбооны технологийн сургуультай танилцаж туршлага судаллаа

Тус сургууль нь холбоо, мэдээллийн технологи, электроник, мэдээллийн сүлжээ аюулгүй байдал, компьютерийн ухаан гэсэн нийт салбартай бөгөөд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий мультимедиа студи болон компьютер, электроникийн иж бүрэн анги танхимд сургалтын үйл ажиллааг явуулж байна

Мэдээллийн технологийн тэнхимийн багш нарыг Мэдээллийн сүлжээ, аюулгүй байдлын салбарын эрхлэгч доктор (Ph.D) Б.Мөнхбаяр болон Холбооны салбарын эрхлэгч доктор (Ph.D), дэд профессор З.Буянхшиг нар хүлээн авч сургалтын хөтөлбөр төлөвлөгөө шинээр нэвтэрч буй шинэ техник технологийн талаар харилцан туршлага солилцож цаашид техникийн боловсрол сургалтын Вэб мультимедиа мэргэжлийн ангийн сургалтын төлөвлөгөө хамтран шинэчлэн боловсруулан төгсөгчдийг үргэлжлүүлэн кр/цаг дүйцүүлэн суралцуулах талаар ярилцаж цаашид хамтын ажиллагааны гэрээг удирдлагын түвшинд байгуулан хамтран ажиллахаар боллоо

